

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НИЙ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

2025 оны 07 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Дүд	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь	
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1	<p>Үүрэг даалгавар НЭГ. Баяр, амралтын өдрүүдэд хөрөнгө оруулалтын ажлыг бүх шатандаа эрчимжүүлж, зураг төсөв, ажлын даалгаваргүй 13 төсөл, арга хэмжээ, тендер шалгаруулалт амжилтгүй болсон 15 төсөл, арга хэмжээнүүдийн эрхийг холбогдох байгууллагуудад шилжүүлж, зарим ажлын санхүүжилтийг татах.</p>	<p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудыг бүх шатанд эрчимжүүлж, зураг төсөв, ажлын даалгаваргүй болон тендер шалгаруулалт амжилтгүй болсон төсөл арга хэмжээнүүдийг чиг үүргийн дагуу Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-т шилжүүлж гүйцэтгүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.</p> <p>Шугам сүлжээ, авто зам, гүүрэн байгууламжийн зураг, төсөв боловсруулах ажлын даалгаваргүй нийт 7-н төсөл арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргуулж яаралтай тендер зарлуулахаар ажиллаж байна.</p>	<p>Тендер шалгаруулалт ад шаардлага хангасан оролцогч байгаагүй.</p>	<p>Удаа тендер амжилтгүй болсон ажлуудыг чиг үүргийн дагуу Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-т яаралтай шилжүүлж тус ажлуудыг гүйцэтгүүлэх.</p>	50
Үүрэг даалгавар ХОЁР. Дүүргүүд хот нийтийн аж ахуйн эрх шилжүүлж авсан ажлуудаа эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих.					
2	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Хөрөнгө гаргах тухай" А/955 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд үүсээд буй үүсмэл хогийн цэгийг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн хооронд арилгах, устгах, цэвэрлэх, цэвэрлэсэн хог хаягдлыг ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулан ажилласан.</p>				90

	Дүүргийн зуслангийн бүс болох 24 дүгээр хороо Гоодой, Өвөр гүнт, Жигжид, Майхан толгой, зуслан, 18 дугаар хороо, Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлтийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн цэвэрлэгээ хийгдсэн байршуулаадад ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан нийт 75,245м2 талбайд ариутгал хийгдсэн.		
Үүрэг даалгавар ГУРАВ. Явган хүний замын тохижилтын ажлыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.			
3	Дүүргийн 1-р хороо монел төвийн ард зам дагуу явган замыг засаж сайжруулах ажил хийж гүйцэтгэсэн. Мөн 3 дугаар хороо их дэлгүүрийн ард байрлах явган хүний зам дагуу зөвшөөрөлгүй баригдсан 8 ширхэг павилоныг буулган тус байршилд тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Тус ажлыг Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ хариуцан ажиллаж байна.		70
Үүрэг даалгавар ДӨРӨВ. Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр дэх 5000 айл өрхүүдийг дулаалж, газын халаагуур тавих ажлыг эрчимжүүлэх.			
4	Дүүргийн 13 дугаар хороонд айл өрхүүдийг дулаалж, газын халаагуур тавих ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байгаа ба нийт 1207 айлын байшинг дулаалахаар төлөвлөснөөс 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 55 байшинг дулаалж, 25 айл гадна фасадаа хийж дуусган газын халаагуур тавих шаардлага хангасан байна.		50
Үүрэг даалгавар ТАВ. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, холбогдох байгууллагууд засвар, тохижилтын ажлаа шуурхай гүйцэтгэж, дуусгах.			
5	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Үндэсний их баяр наадмын үеэр худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих тухай" А/91 дугаар тушаалын хүрээнд Үндэсний их баяр наадмын үеэр Хүй долоон худагт хариуцсан сектор, талбайд худалдаа 11, хоол үйлдвэрлэл 44, тоглоомын үйлчилгээ 16 нийт 71 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулж, бэлтгэл ажлыг ханган, хяналт тавин ажилласан. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК 07 дугаар сарын 11-ний өдрөөс 07 дугаар сарын 14-ний өдөр хүртэл ХҮЙ-7 худагт хариуцсан бүсийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ахуйн хог хаягдал тээвэрлэлтийг хариуцан бүсэд нийт зам талбайн 3 үйлчлэгч, хог тээврийн битүү шахдаг 1 авто машинтайгаар тус тус ажилласан. Баяр наадмын амралтын өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ахуйн хог хаягдал тээвэрлэлтийг хуваарийн дагуу гүйцэтгэгч хоёр байгууллага хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган зам талбайн 68 үйлчлэгч, 32 хог тээврийн машин, 54 ачигтайгаар ажилласан. Тус хугацаанд цэвэрлэгээ үйлчилгээ, хог тээвэрлэлттэй холбоотой зөрчил гараагүй болно.		100

<p>Үүрэг даалгавар ЗУРГАА. Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж, урьдчилан сэргийлэх.</p>	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Үндэсний их баяр наадмын үеэр худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих тухай” А/91 дугаар тушаалын хүрээнд Үндэсний их баяр наадмын үеэр Хүй долоон удагт үйл ажиллагаа явуулах худалдаа 11, хоол үйлдвэрлэл 44, тоглоомын үйлчилгээ 16 нийт 71 иргэн, аж ахуйн нэгжид 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс хамтран холбогдох чиглэлээр сургалт зохион байгуулсан. Мөн баяр наадмын үеэр тус байгууллагуудтай хамтран хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан.</p>	<p>Үүрэг даалгавар ДОЛОО. Баяр наадмын хуушуур, хоол үйлдвэрлэл хийх эрхийг хууль бусаар зарж байгаа асуудлыг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах.</p>	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Үндэсний их баяр наадмын үеэр худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих тухай” А/91 дугаар тушаалын хүрээнд Үндэсний их баяр наадмын үеэр худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээг Онлайн бизнес төвийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ээр хүсэлтийг хүлээн авч, нөхцөл шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан.</p>	<p>Үүрэг даалгавар НАЙМ. Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, иргэд болон байгууллагыг ус, цахилгаан хангамжаар тасалдуулахгүй байхад анхаарч, бэлэн байдлыг хангах.</p>	<p>Үндэсний их баяр наадмын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах, иргэд болон байгууллагын ус, цахилгаан хангамжаар тасалдуулахгүй байлгах ажлыг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх ХҮТ-7, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган ус, цахилгаан хангамжаар ханган ажилласан. Тус хугацаанд зөрчил гараагүй болно.</p>	<p>Үүрэг даалгавар ЕС. Үндэсний их баяр наадмаас өмнө ус тогтдог байршлуудыг засварлаж, хөв цөөрөм байгуулах бэлтгэл ажлыг хангаж, дунд голын далангийн ажлыг шуурхай зохион байгуулах</p>	<p>Дүүргийн 1-6 дугаар хороо болох төвийн байшин хороолол дунд авто замын эвдэрч гэмтсэн борооны ус ихээр тогтдог нийт 3 байршилд шороогоор дүүргэх, түрж тэгшлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн болно.</p>	<p>Үүрэг даалгавар АРАВ. Баяр наадмын өдрүүдэд үер ус, гамшиг осол, гал түймрийн аюул болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг эрчимжүүлэх. ОБХ</p>
6	100		100	100		100		

10	<p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны А/251 дүгээр захирамжийн хүрээнд Шуурхай штаб-д 3 цаг тутамд гал түймэр, гамшиг ослын талаарх дуудлага мэдээллийг хүргэж, үүрэг гүйцэтгэсэн. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний А/37 дугаар Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг томилох тухай А37 дугаар захирамжийн хүрээнд 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд тус хэлтсийн 8 офицер, 8 удаа ерөнхий эргүүлийн үүргийг гүйцэтгэн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж Нийслэлийн Онцгой байдлын газрын ерөнхий эргүүл рүү 2 цаг тутамд мэдээллээ өгч ажилласан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны А/243 дугаар захирамжийн хүрээнд Маршалын гүүрнээс Хан Усан тохой хүртэл тус хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бэлтгэл ээлжийн алба хаагчид 1 автомашинтайгаар хөдөлгөөнт эргүүлийн үүргийг гүйцэтгэж яриаг 2600 иргэнд (том хүн-1800 хүүхэд 800) хүргэж, 1800 ширхэг тараах материал тараан, голын эргээс 0 автомашин холдуулан ажиллалаа. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн фэйсбүүк цахим хуудсанд "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх", "Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх" "Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх" нийт 15 удаагийн сэрэмжлүүлэг /постер/, 2 удаагийн рийл сэрэмжлүүлэг, 10 мэдээ, мэдээллийг байршуулан, Онцгой байдлын Ерөнхий газар цахим фэйсбүүк хуудас 25, Нийслэлийн Онцгой байдлын газар фэйсбүүк хуудас 25, нийт 50 удаагийн сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс фэйсбүүк цахим хуудсанд оруулан түгээж, мөн Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодын иргэдийн албан ёсны фэйсбүүк групп рүү 40 удаа түгээж ажилласан. MN тауэр гадна лед дэлгэцээр 50 удаа, 1-24 дүгээр хороодын байрны лед дэлгэцээр шторкыг түгээж иргэд, олон нийтэд сэрэмжлүүлж ажилласан.</p> <p>Баяр амралтын өдрүүдэд Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн гал түймрийн 6 дуудлага бүртгэгдэж анги унтраасан-5, иргэд унтраасан-1 дуудлагатай, үер, усны дуудлагагүй.</p>		100
<p>Үүрэг даалгавар АРВАН НЭГ. Баяр наадмын өдрүүдэд байгууллагууд хариуцлагатай жижүүр ажиллуулах.</p>			
11	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн "Үндэсний их баяр наадам"-ын өдрүүдээр хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай А/256 дугаар тушаалаар төрийн байгууллагын байранд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, шуурхай арга хэмжээ авч ажиллах хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх албан хаагчдын нэрс, хуваарийг баталсан. Дүүргийн 1-24 дүгээр хороодод ажиллах хариуцлагатай жижүүрийн захирамжийг 24 хороодоос авч нэгтгэн хавтаст байршуулсан. Баяр наадмын өдрүүд болох 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 17-ны өдрүүдийн хугацаанд нийт Тамгын газрын байранд 8 хариуцлагатай</p>		100

	<p>жижүүр үүрэг гүйцэтгэн дүүргийн 1-24 дүгээр хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас 07:00, 10:00, 13:00, 16:00 цагуудад цагийн мэдээ авч ажилласан. Наадмын амралтын өдрүүдэд ноцтой зөрчил дуудлага бүртгэгдээгүй. Цэвэрлэгээ, үйлчилгээ, цахилгаан, замын хөдөлгөөнтэй холбоотой дуудлага мэдээллийг цаг тухай бүр холбогдох байгууллага болон газар дээр нь очиж ажиллан, зөрчлийг арилгасан болно.</p>			
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ				87,2

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

М.НАВЧАА

НЭГТГЭЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН